



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/43

Улаанбаатар хот

Хөтөлбөр, төлөвлөгөө батлах  
тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 262 дугаар зүйлийн 262.1.2, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын 2.3 дахь заалтууд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын зөвлөлийн 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн ээлжит хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийн нийгмийн хамгааллыг бэхжүүлэх 2021-2024 оны дунд хугацааны хөтөлбөр”-ийг нэгдүгээр, Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг зохих зардлаас гаргахыг Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газар /хурандаа Н.Цэвэлмаа/-т зөвшөөрсүгэй.

3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг алба, газар, хэлтэс, хорих анги, байгууллагын дарга нарт, гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны удирдлагын газар /хурандаа С.Батбямба/-т тус тус даалгасугай.

ДАРГА,  
ХУРАНДАА

Д.ЗАГДЖАВ

1501011198

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021 оны 02 дугаар сарын 23 - ны өдрийн 4/33 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН  
ХААГЧИЙН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ БЭХЖҮҮЛЭХ  
ДУНД ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨР  
/2021-2024 он/

**Нэг. Нийтлэг үндэслэл:**

1.1. Хөтөлбөрийн зорилго:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тэдний идэвх санаачилгатай, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх, ахмад настны нийгмийн хамгааллын үйлчилгээг хүртээмжтэй, жигд хүргэх чиглэлээр салбарын стратеги зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд оршино.

1.2. Хөтөлбөрийн эрх зүйн үндэслэл:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийн нийгмийн хамгааллыг бэхжүүлэх дунд хугацааны хөтөлбөр нь /цаашид хөтөлбөр гэх/ дараах хууль тогтоомж, журам заавар, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах хүрээнд зохион байгуулагдана.

1.2.1. Монгол Улсын хууль:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль
- Ахмад настны тухай хууль.

1.2.2. Хуульд нийцүүлэн гаргасан эрх зүйн акт:

- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 362 дугаар тогтоолоор батлагдсан “ШШГБ-ын албан хаагчид нөхөх олговор, тусламж олгох журам”;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 08 дугаар тогтоолоор батлагдсан “Албан үүргээ гүйцэтгэх явцад төрийн албан хаагчийн амь нас хохирсон тохиолдолд ар гэрт нь нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”;
- ШШГЕГ-ын даргын 2013 оны А/35 дугаар тушаалаар батлагдсан “ШШГБ-ын албан хаагчдын орон сууцны асуудлыг шийдвэрлэхэд баримтлах журам”;
- ШШГЕГ-ын даргын 2017 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын Хүний нөөцийн журам”;
- ШШГЕГ-ын 2017 оны А/236 дугаар тушаалаар батлагдсан “ШШГБ-ын амралт, сувиллын газрын үйл ажиллагаанд баримтлах журам”;
- ШШГЕГ-ын даргын 2020 оны А/96 дугаар тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”.

### 1.2.3. Хөтөлбөрийн бодлогын үндэслэл:

- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг;
- Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл;
- Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр.
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөр. /ХЗС-ийн 2016 оны А/121 дүгээр тушаал/
- ШШГЕГ-ын даргын 2020 оны А/91 дүгээр тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бодлогын хөгжлийг бэхжүүлэх дунд хугацааны хөтөлбөр”;

### 1.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим:

#### 1.3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Хууль дээдлэх;
- Шударга ёсыг сахих;
- Ил тод байдлыг хангах;
- Шуурхай, тасралтгүй байдлыг хангах;
- Судалгаа, шинжилгээний үр дүнд үндэслэсэн байх;
- Үл ялгаварлах;
- Алба хаагч, ахмад настныг тэгш боломжоор хангах;
- Удирдлагын шийдвэр цаг үеэ олсон байх;
- Бодитой, үр дүнд хүрэхүйц байх.

### 1.4. Хөтөлбөр боловсруулах хэрэгцээ шаардлага:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд төв, орон нутгийн анги, байгууллагын албан конторын орчин нөхцөлийг сайжруулах, албан хаагчдын орон сууцны хангалтыг нэмэгдүүлэх, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийн хүрээнд үе шаттайгаар зохион байгуулан хэрэгжүүлж ирсэн.

ШШГЕГ-ын даргын 2016.11.14-ний өдрийн А/220 дугаар тушаалаар “ШШГБ-ын алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг батлан 2016-2020 оны хугацаанд хэрэгжүүлэх жил бүрийн төлөвлөгөөг батлан, тодорхой үр дүнтэйгээр хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажилласан.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийн нийгмийн хамгааллыг бэхжүүлэх 2021-2024 оны дунд хугацааны хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулах дараах хэрэгцээ, шаардлага үүсэж байна. Үүнд:

- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн 5 дугаар зорилтын 5.4.9 дэх хэсгийн “Төрийн албан хаагчийн нэр хүндийг дээшлүүлж, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зохистой тогтолцоог төлөвшүүлэх”, 5.4.12 дахь хэсгийн “Төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэл, чиг үүргийн онцлогт тохирсон үе шаттай, тасралтгүй сургалтын тогтолцоог төлөвшүүлэх” гэсэн заалтууд;

- Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр бүлгийн Засаглалын бодлого, Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба, Амар тайван, аюулгүй нийгэм дэд зорилтын хүрээнд хууль сахиулах байгууллагын өмнө тавигдсан үүрэг, зорилтуудыг хэрэгжүүлэхэд албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулан, албан хаагчид болон ахмад настны нийгмийн хамгааллын үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэх арга хэмжээг тодорхой бодлого, хөтөлбөртэйгээр тасралтгүй зохион байгуулах зайлшгүй шаардлага бий болсон.

- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-д байгууллагын жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөө нь төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт үндэслэнэ гэж заасныг баримтлан уг хөтөлбөрийг боловсруулах нь нэн тэргүүний шаардлага болно.

- Орон нутаг дахь шийдвэр гүйцэтгэх газрын албан конторыг шинээр барих, шинэчлэн засварлах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж байгаа боловч өнөөдрийн байдлаар Төв, Баян-Өлгий, Өмнөговь, Говьсүмбэр, Дархан-Уул, Хэнтий аймаг дахь ШШГГ, Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллага зэрэг зарим анги, байгууллагын албан хаагчдын ажиллах орчин нөхцөл стандарт шаардлагад бүрэн нийцэхгүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь нийт 3198 албан хаагч үүрэг гүйцэтгэдэг. Үүнээс эмэгтэй 1074, эрэгтэй 2124, орон нутагт 1687 /эрэгтэй 1231, эмэгтэй 456/ албан хаагч үүрэг гүйцэтгэж байна. Иймд:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа орон нутаг дахь анги, байгууллагууд нь төв суурин газраас алслагдсан байршилд үйл ажиллагаа явуулдаг тул шинээр болон шилжин томилогдож буй албан хаагчдын орон сууц, гэр бүлийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлт, хүүхдийн сургууль, цэцэрлэгийн асуудлыг шийдвэрлэх;

- Нийслэл, аймгийн төвөөс бусад алслагдсан нутаг дэвсгэрт тасралтгүй 5 болон түүнээс дээш жил ажиллаж байгаа албан хаагчдад мөнгөн урамшил олгох эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдад мэргэжлийн ур чадварын зэргийн нэмэгдэл олгох асуудлыг судлан, шийдвэрлэх зайлшгүй шаардлага үүсэж байна.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд нийт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилсан болон нарийвчилсан үзлэг шинжилгээнд жил бүр хамруулж байгаа боловч түүний мөрөөр эмчилгээ, сувилгаа хийлгэх боломж нөхцөлөөр бүрэн хангагдахгүй байна.

- Төрийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Ахмад настны тухай хууль зэрэг төрийн хууль тогтоомжид албан хаагчдын нийгмийн хамгааллыг бэхжүүлэх чиглэлээр заасан төрийн байгууллагын хүлээх үүрэг, өнөөгийн тавигдаж буй шаардлагыг тус тус харгалзан дээрх баримт бичгүүдийг нэгтгэн хэрэгжүүлэх бодлогын зорилт, арга хэмжээг боловсронгуй болгон тодорхойлон баталгаажуулах зайлшгүй хэрэгцээ үүсэн бий болж байна.

## **Хоёр.Стратегийн зорилтууд:**

2.1. Тус хөтөлбөрийг дараах зорилтуудын хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

**1 дүгээр зорилт:** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагч, ахмад настны нийгмийн хамгааллыг бэхжүүлэхэд чиглэгдсэн эрх зүйн баримт бичиг, үйл ажиллагааны төлөвлөлтийг төрийн бодлого, шийдвэрт нийцүүлэн боловсронгуй болгох;

**2 дугаар зорилт:** Байгууллагын хэмжээнд албан хаагчийн ажлын байрны орчин нөхцөл, албаны үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулах, эрүүл ахуй, аюулгүй байдлын стандарт, шаардлагад нийцүүлэх;

**3 дугаар зорилт:** Албан хаагчдын албан тушаалын чиг, үүргээ хэвийн хэрэгжүүлэхэд шаардагдах эрх зүйн болон нийгэм, эдийн засгийн баталгааг бүрэн ханган, тэдний тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх;

**4 дүгээр зорилт:** Албан хаагчдын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх арга хэмжээг тэдний авьяас чадварыг нээн илрүүлэх, хөгжүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх шаардлагатай уялдуулан хэрэгжүүлэх;

**5 дугаар зорилт:** Албан хаагч, ахмад настнуудын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах бодлогын үйл ажиллагааг тогтмолжуулан, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх;

**6 дугаар зорилт:** Ахмад настанд үзүүлэх үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэх, дэмжлэг, туслалцааг тогтмол үзүүлэх.

### **Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат:**

3.1. Тус хөтөлбөрийг 2021-2024 онд 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

**3.1.1. I үе шат:** 2021 онд ШШГЕГ-ын даргын 2016.11.14-ний өдрийн А/220 дугаар тушаалаар батлагдсан “ШШГБ-ын алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн батлагааг хангах хөтөлбөр”, “Ахмад настны талаар авах зарим арга хэмжээний тухай” Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2016.11.02-ны өдрийн 03 дугаар албан даалгаврын хэрэгжилтийн байдалд үр дүн, гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний бодлого, чиглэлийг тодорхойлно. Байгууллагын хэмжээнд алба хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах чиглэлээр мөрдөгдөж буй баримт бичгүүдэд судалгаа шинжилгээ хийж, өөрчлөн шинэчлэх арга хэмжээг тодорхойлж хэрэгжүүлнэ.

**3.1.2. II үе шат:** 2022-2024 онд байгууллагын үндсэн чиг үүрэг, хөгжлийн стратеги төлөвлөгөөнд үндэслэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийн нийгмийн хамгааллыг бэхжүүлэхэд чиглэсэн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг оновчтой төлөвлөн баталгаажуулж хэрэгжүүлэх.

### **Дөрөв.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ:**

4.1. Хөтөлбөрт тусгагдсан зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

4.1.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагч, ахмад настны нийгмийн хамгааллыг бэхжүүлэхэд чиглэгдсэн эрх зүйн баримт бичиг, үйл ажиллагааны төлөвлөлтийг төрийн бодлого, шийдвэрт нийцүүлэн боловсронгуй болгох гэсэн **1 дүгээр зорилтын хүрээнд:**

- Байгууллагын хэмжээнд албан хаагчийн ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах чиглэлээр мөрдөгдөж буй баримт бичгүүдийн хэрэгжилт, үр нөлөөнд дүн шинжилгээ хийх. /2021-2022 он/

- Судалгааны үр дүнг үндэслэн албан хаагчдын дунд хэлэлцүүлэг, санал асуулга явуулан, дүнг нэгтгэж, албан хаагчдын нийгмийн хамгааллын асуудлыг зохицуулж буй хууль, бусад эрх зүйн актууд болон бодлогын баримт бичгүүдэд нэмэлт өөрчлөлт оруулах санал, төслийг боловсруулан зохих түвшинд уламжлан шийдвэрлүүлэх. /2021-2022 он/

- Албан хаагч, ахмад настны нийгмийн хамгааллыг бэхжүүлэхэд чиглэгдсэн хууль тогтоомж, эрх зүйн акт, бодлогын баримт бичгүүдийг чанд мөрдөн, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцох. /2021-2024 он/

- Байгууллагын жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд албан хаагч, ахмад настнуудын нийгмийн хамгааллыг бэхжүүлэх талаар арга хэмжээг болон хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх асуудлыг тусган дүгнэх. /2021-2024 он/

4.1.2. Байгууллагын хэмжээнд албан хаагчийн ажлын байрны орчин нөхцөл, албаны үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулах, эрүүл ахуй, аюулгүй байдлын стандарт шаардлагад нийцүүлэх гэсэн **2 дугаар зорилтын хүрээнд:**

- Байгууллага бүр албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлыг жил бүр төлөвлөн, санхүүжилтийн асуудлыг тухайн жилийн төсвийн төсөвт тусгах болон байгууллагын дотоод эх үүсвэрээр бүрдүүлэх. /2021-2024 он/

- Төв байгууллага болон салбар нэгжийн хэмжээнд албан хаагчдын ажлын өрөө тасалгаа, бусад ажлын орчинг төрийн албаны стандартын шаардлагад нийцүүлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх. /2021-2024 он/

- Байгууллагын хэмжээнд албан тушаалын ажлын байрны орчин нөхцөлд эрүүл ахуй, аюулгүй байдлын талаар дүн шинжилгээ хийж хэвших. /2021-2022 он/

- Албан хаагчдаас жил бүр ажлын байрны сэтгэл ханамжийн судалгаа авч, дүгнэлт гарган, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон, хэрэгжилтийг хангах. /2021-2022 он/

- Ажлын орчин нөхцөл, хангамжийг хүйсийн ялгаатай байдал, онцлог хэрэгцээнд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих ажлыг удирдлагын түвшинд хэрэгжүүлэх. /2021-2022 он/

- Албаны үйл ажиллагааг дэвшилтэт техник, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг тогтмолжуулах. /2021-2024 он/

- Албан хаагчийн албан ажилд шаардлагатай эрүүл ахуй, халдвар хамгаалал, бичиг хэргийн хэрэгцээт зүйлсээр зохих түвшинд хангах. /2021-2024 он/

- Албан хаагчийн батлагдсан нормативын шаардлагад нийцүүлэн ажлын ачаалалд дүн шинжилгээ хийн, удирдлагын түвшинд шийдвэр гаргах талаар санал уламжлах. /2021-2022 он/

- Орон тоог үе шаттай нэмэгдүүлэх асуудлыг эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх. /2021-2024 он/

- Албан хаагчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор нэг бүрийн бие хамгаалах тусгай хэрэгслээр хангаж, албаны тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг тогтмол хангах./2021-2024 он/

- Албан хаагчдын дүрэмт хувцас, хэрэглэлийг хууль тогтоомжид заасны дагуу бүрэн, хугацаанд нь олгох ажлыг хэвшүүлэх. /2021-2024 он/

4.1.3. Албан хаагчдын албан тушаалын эрх, үүргээ хэвийн хэрэгжүүлэхэд шаардагдах эрх зүйн болон нийгэм, эдийн засгийн баталгааг бүрэн ханган, тэдний тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх гэсэн **3 дугаар зорилтын хүрээнд;**

- Төрийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон бусад хууль тогтоомж, журам, зааварт тусгагдсан нийгмийн баталгааг бүрэн хангуулахад чиглэсэн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх. /2021-2024 он/

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд албан хаагчдын амьжиргааны түвшинг тогтоох суурь судалгаа хийж, судалгааны үр дүнд суурилан нийгмийн хамгааллын талаар авах арга хэмжээг оновчтой зохион байгуулах. /2021 он/

- Албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан тусгай шалгуур, шаардлага, ажил үүргийн онцлог, ажлын нөхцөлийг харгалзан удирдах болон гүйцэтгэх түвшний албан хаагчдын цалинг үе шаттай нэмэгдүүлэх асуудлыг эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх. /2021-2024 он/

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан тушаалын мэргэжлийн ур чадварын зэргийн нэмэгдэл олгох журам боловсруулан, эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлэх. /2021-2023 он/

- Албан хаагчийн шинэ санаа, бүтээлч санаачилгыг дэмжин урамшуулах тогтолцоог бий болгох замаар ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх. /2021-2024 он/

- Нийслэл, аймгийн төвөөс бусад алслагдсан нутаг дэвсгэрт тасралтгүй 5 болон түүнээс дээш жил ажиллаж байгаа алба хаагчдад мөнгөн урамшил олгох эрх зүйн зохицуулалтыг бий болгох төсөл боловсруулан шийдвэрлүүлэх. /2021-2022 он/

- Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгч нарт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан “Ялантай ажилласны нэмэгдэл”-ийг олгох талаарх арга хэмжээг бодлогын түвшинд уламжлан, шийдвэрлүүлэх. /2021-2023 он/

- Албан хаагч, ахмад настны амьдралын зайлшгүй шаардлага, нөхцөлийг үндэслэн нэг удаагийн тэтгэмж, буцалтгүй тусламж олгох арга хэмжээг хууль, журмын хүрээнд оновчтой зохион байгуулах. /2021-2024 он/

- Байгууллагын албан хаагчдын хүүхдийн сурч боловсрох, мэргэжил, мэргэшлээ дээшлүүлэх, өсөж хөгжих боломжийг нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх зорилгоор дотоодын болон гадаад улсын их, дээд сургуульд элсэн суралцах хүүхдийн сургалтын төлбөрийг байгууллага хариуцах ажлыг тогтмолжуулах. /2021-2024 он/

- Албан хаагчдыг хөнгөлөлттэй нөхцөлөөр болон зах зээлийн үнээс хямд үнэтэй орон сууцаар хангах хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, чанартай, ая тухтай орон сууц худалдан авах, орчин, ахуй нөхцөлөө дээшлүүлэхэд /хашаа байшин, гэр/ нь дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэх. /2021-2024 он/

- Орон нутагт шилжин томилогдон ажиллаж байгаа албан хаагчийн албаны орон сууцаар хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх. /2021-2024 он/

- Гэрт болон галлагаатай байшинд амьдардаг албан хаагчдад түлээ, нүүрс худалдан авахад дэмжлэг үзүүлэх. /2021-2024 он/

- Өрх толгойлсон, олон хүүхэдтэй болон гэр бүлийн гишүүдийн дотор хөгжлийн бэрхшээлтэй, хүнд өвчтэй иргэн байгаа, арчилгаа, асрамж шаардлагатай эцэг, эхээ асардаг албан хаагчдад тусламж, дэмжлэг үзүүлэх. /2021-2024 он/

- Залуу гэр бүл, шинээр гэр бүл болсон албан хаагчийн гэр бүлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор тулгамдаж буй асуудлын хэрэгцээ шаардлагыг тодорхойлон, шаардлагатай дэмжлэг, тусламж үзүүлэх ажлыг тогтмолжуулах. /2021-2024 он/

- Хөгжлийн бэрхшээлтэй, асаргаа сувилгаа шаардлагатай хүүхэдтэй албан хаагчдыг хууль тогтоомжийн хүрээнд богиносгосон цагаар ажиллуулах асуудлыг бодлогын түвшинд шийдвэрлүүлэх. /2021-2024 он/

- Хот суурин газраас алслагдсан байрлалд байгаа хорих анги, байгууллагын дэргэд хүүхдийн цэцэрлэг байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх. /2021-2024 он/

- Хүүхдийн хөгжил, хамгаалал, мэдлэг, боловсрол, хүмүүжил төлөвшлийг сайжруулах чиглэлээр албан хаагчид, тэдний гэр бүлийн гишүүд, хамт олны санаачилгаар олон нийтийн байгууллага, зөвлөлтэй хамтран хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг оновчтой, үр дүнтэй зохион байгуулах. /2021-2024 он/

- Хот суурин газраас алслагдсан байрлалд томилогдсон албан хаагчийн гэр бүлийн гишүүнийг ажлын байраар хангах талаар дэмжлэг үзүүлэх ажлыг үргэлжлүүлэн холбогдох төр, захиргааны байгууллагатай хамтран ажиллах. /2021-2024 он/

- Албан хаагч, түүний гэр бүлийн гишүүдийг албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан хүчирхийлэл, заналхийлэл, доромжлол, гүтгэх болон бусад хууль



бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалалтад авах зохион байгуулалтын арга хэмжээ авах. /2021-2024 он/

4.1.4. Албан хаагчдын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх арга хэмжээг тэдний авьяас чадварыг нээн илрүүлэх, хөгжүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх шаардлагатай нягт уялдуулан хэрэгжүүлэх гэсэн **4 дүгээр зорилтын хүрээнд:**

- Төв байгууллага болон салбар нэгж бүр албан хаагч, ахмад настны дунд соён гэгээрүүлэх, эрүүл аж төрөх чиглэлээр сургалт, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах, бие даан өөрийгөө хөгжүүлэх сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах./2021-2024 он/

- Албан хаагчийг сэтгэл зүйн сөрөг үйлчлэлээс ангижруулах сэтгэл, заслын үйлчилгээ үзүүлэх, алжаал тайлах зориулалт бүхий өрөөг анги, байгууллагад бий болгон, үйл ажиллагааг тогтмолжуулах. /2021-2024 он/

- Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх, биеийн тамир, спортын үйл ажиллагаа явуулах зорилгоор бялдаржуулах танхим, спорт заалыг бий болгох. /2021-2024 он/

- Байгууллагын хэмжээнд спортын дугуйлан ажиллуулах, албан хаагч болон тэдний гэр бүлийн гишүүдийн дунд төрөл бүрийн уралдаан, тэмцээн тогтмол зохион байгуулах. /2021-2024 он/

- Албан хаагч болон гэр бүлийн гишүүдийн дунд байгууллагын зүгээс мөн төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах. /2021-2024 он/

4.1.5. Албан хаагч, ахмад настнуудын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах бодлогын үйл ажиллагааг тогтмолжуулан, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх гэсэн **5 дугаар зорилтын хүрээнд:**

- Албан хаагч, ахмад настны дунд мэргэжлээс шалтгаалах болон бусад өвчлөлийн талаар төрөлжүүлсэн судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг тогтмолжуулах. /2021 он/

- Албан хаагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл аж төрөх, эрүүл мэндээ хамгаалах, анхан шатны тусламж үзүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах. /2021-2024 он/

- Албан хаагч, ахмад настанг жил бүр урьдчилан сэргийлэх болон нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээнд хамруулан шаардлагатай эмчилгээ, сувилгаа хийлгэх боломжоор хангах. /2021-2024 он/

- Албан хаагчийн ур чадвар, зан төлөвшил нь тухайн албан тушаалыг гүйцэтгэхэд шаардагдах шаардлагуудтай тохирох эсэхийг нягтлах зорилгоор сэтгэл зүйн тестийн судалгаа хийж, үр дүнг тооцох, энэ чиглэлээр мэргэшсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэх. /2021-2022 он/

- Албан хаагчийн сэтгэл зүйг тогтворжуулах, стрессийг бууруулах сургалтыг тогтмол зохион байгуулж, үр дүнг тооцох. /2021-2024 он/

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд албан хаагч болон ахмад настны эрүүл мэндийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх “Төр хур” нөхөн сэргээх сувиллын үйл ажиллагааг өргөтгөн тогтмолжуулах. /2021-2024 он/

- Амралт, сувиллын газруудтай хамтран ажиллах гэрээ байгуулан, албан хаагч, ахмад настанг үнэ төлбөргүй болон хөнгөлттэй үнээр амруулахад дэмжлэг үзүүлэх ажлыг эрчимжүүлэх. /2021-2024 он/

- Албан хаагч, ахмад настанд эмнэлгийн тусламж, үйлчилгээг тасралтгүй, чанартай үзүүлэх чиглэлээр эрүүл мэндийн төрийн болон төрийн бус байгууллага, алба, нэгжтэй хамтын ажиллагааг өргөжүүлэн зохион байгуулах /2021-2024 он/

- Албан хаагч, ахмад настны гадаад, дотоодын эмнэлэгт эмчлүүлэх, амралт, рашаан сувилалд сувилуулахад дэмжлэг үзүүлж, хүнд өвчтэй албан хаагчийн эмчилгээний зардлыг бүрдүүлэхэд аян зохион байгуулах ажлыг тогтмолжуулах. /2021-2024 он/

- Хөгжлийн бэрхшээлтэй албан хаагч, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг, тусламж үзүүлэх. /2021-2024 он/

- Төв байгууллага болон салбар нэгж хорт зуршлаас татгалзах, амьдралын зөв дадал хэвшилтэй болох, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх, хэвшүүлэх арга хэмжээг зохион байгуулах. /2021-2024 он/

4.1.6. Ахмад настанд үзүүлэх үйлчилгээг сайжруулан, зохих дэмжлэг, туслалцаа үзүүлэх гэсэн **6 дугаар зорилтын хүрээнд:**

- Өндөр насны тэтгэвэр тогтоолгох хугацаа дөхсөн болон өндөр насны тэтгэвэр тогтоолгож байгаа ахмад настныг нийгэм, эдийн засаг, сэтгэл зүйн хувьд бэлтгэх арга хэмжээг тодорхой төлөвлөгөөний дагуу зохион байгуулах. /2021-2024 он/

- Ахмад настны аж байдлыг дээшлүүлэх зорилгоор амьдралын чанарын болон өвчлөлийн талаар судалгаа хийж, сууцны болон бусад дэмжлэг, туслалцаа, үйлчилгээ үзүүлэх. /2021-2024 он/

- “Ахмадын сан” байгуулах үйл ажиллагааг нь бэхжүүлж, “Ахмадын хороо”-ны ажлыг тогтмолжуулан, дэмжиж урамшуулах арга хэмжээг хэрэгжүүлэх. /2021-2024 он/

- Ахмад настанд асрамж, халамжийн үйлчилгээ, дэмжлэг туслалцаа үзүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус, буяны болон шашны байгууллагатай хамтран ажиллах. /2021-2024 он/

- Ахмад настанд зориулан чөлөөт цагийн танхим, орчинг бий болгох. /2021-2024 он/

- Тэмдэглэлт үйл явдал болон бусад баярыг тохиолдуулан шагнаж урамшуулах ажлыг тогтмолжуулах. /2021-2024 он/

- Ахмад настны спортын баг, соёл, урлагийн хамтлаг, сонирхлын бүлэг, клубийг байгуулах, биеийн тамир, спорт, соёл, урлагийн арга хэмжээг зохион байгуулах. /2021-2024 он/

- Ахмад настны туршлагыг дэлгэрүүлэх, мэргэжлийн ур чадварыг нь залуучуудад өвлүүлэх, ахмадаасаа суралцах, ахмад үеэ хүндэтгэж, дэмжин тусалдаг уламжлалт ёс заншлыг хадгалахад байгууллага, хамт олон, гэр бүлийн хамтын үйл ажиллагааг чиглүүлэх. /2021-2024 он/

- Ахмад настнууд залуу хойч үедээ ажил, амьдралын туршлагаасаа хуваалцах, зөвлөгөө өгөх, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах зэргээр тэдний идэвх, санаачлагыг хөхүүлэн дэмжих. /2021-2024 он/

### **Тав. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт:**

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

5.1.1. Хууль, эрх зүйн акт, бодлогын баримт бичгүүдэд албан хаагчдын нийгмийн хамгааллыг бэхжүүлэх үзэл санаа туссан байх;

5.1.2. Эрх зүйн зөрчил, давхардал, хийдэл арилсан байх;

5.1.3. Албан хаагчдын ажиллах орчин нөхцөл төрийн албаны стандарт шаардлагад нийцсэн байдал;

5.1.4. ШШГБ-ын албан хаагчдын ажлын ачаалал тэнцвэржиж, орон тоог зохистой тогтоон баталгаажуулсан байдал;

5.1.5. Албан хаагчдын цалин бусад нэмэгдэл, урамшууллыг үе шаттай нэмэгдүүлсэн байдал;

5.1.6. Хот суурин газраас алслагдсан байрлалд томилогдсон албан хаагч тэдний гэр бүлийн гишүүдийн нийгмийн хамгааллын чанар, үр нөлөө;

5.1.7. Орон сууцны хангамж болон бусад нийгмийн баталгааг хангах арга хэмжээний чанар, үр нөлөө;

5.1.8. Албан хаагчдын дунд олон нийтийн арга хэмжээ зохион байгуулснаар тэдний ажлын бүтээмж, хүсэл сонирхол, идэвхи, чармайлт дээшилсэн байх;

5.1.9. Байгууллагын хэмжээнд албан хаагчдын сэтгэл засал, алжаал тайлах зориулалт бүхий өрөө нэмэгдсэн тоон үзүүлэлт;

5.1.10. Албан хаагчдын эрүүл мэндийн боловсрол дээшилж, өвчлөл буурсан тоон үзүүлэлт;

5.1.11. Сувиллын үйл ажиллагаа тогтмолжин, үйлчилгээний чанар хүртээмж дээшилсэн байх;

5.1.12. Албан хаагчдын норматив, бие бялдрын шалгуур үзүүлэлтийг хангасан байдал;

5.1.13. Ахмад настны нийгмийн баталгааг бэхжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний чанар, үр дүн;

5.1.14. Ахмадын хороо, салбар зөвлөлийн үйл ажиллагааны тогтмолжсон байдал.

### **Зургаа. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ:**

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хагас жилээр үр дүнд суурилсан явцын үнэлгээ, бүтэн жилээр үр дүнд суурилсан эцсийн үнэлгээг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хийнэ.

6.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хагас, бүтэн жилээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулна.

### **Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт:**

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ. Үүнд:

7.1.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон харьяа алба, хорих анги, салбар нэгжийн жил бүрийн төсөвт тусгагдан батлагдсан хөрөнгө.

7.1.2. Олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын төсөл, хөтөлбөр, хандив, буцалтгүй тусламж.

### **Найм. Хөтөлбөрийн үр дүн:**

8.1. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

#### **1 дүгээр зорилтын хүрээнд:**

- Байгууллагын хэмжээнд албан хаагч, ахмад настны нийгмийн баталгааг бэхжүүлэх чиглэлээр мөрдөгдөж буй эрх зүйн болон бодлогын баримт бичгүүдийг шинэчлэн боловсронгуй болгосон байна.

- Эрх зүйн болон бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, үр нөлөөнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, гүйцэтгэлийг сайжруулах арга хэмжээг тодорхойлогдсон байна.

#### **2 дугаар зорилтын хүрээнд:**

- Албан хаагчдын албаны үйл ажиллагаа явуулах орчин нөхцөл, эрүүл, аюулгүй байдал төрийн албаны стандартын шаардлагад нийцсэн байна.

- Албан хаагчдын ажлын ачаалал тэнцвэржиж, үйл ажиллагаа жигдэрч, ажиллах урам зориг нэмэгдсэн байна.

- Албан хаагчийн аюулгүй байдал хангагдсан байна.

#### **3 дугаар зорилтын хүрээнд:**

- Албан хаагчийн нийгмийн баталгааг олгосон хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.

- Нийгмийн баталгаа олгосон хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.

- Албан хаагч, ахмад настанд үзүүлэх тусламж, тэтгэмжийн төрөл нэмэгдэж, дэмжлэг үзүүлэх ажил тогтмолжино.

- Албан хаагч, ахмад настан хөнгөлттэй нөхцөл, хямд үнэтэй орон сууцаар хангагдаж, амьдралын түвшин, ахуй нөхцөлийг дээшилнэ.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд албан хаагчдын амьжиргааны түвшин дээшилсэн байна.

#### **4 дүгээр зорилтын хүрээнд:**

- Байгууллагын хэмжээнд спортын дугуйлан түүний төрөл нэмэгдэж, уралдаан тэмцээн тогтмол зохион байгуулагдсан байна.

- Албан хаагчд, ахмад настан эрүүл чийрэг, идэвхтэй амьдралын хэв маяг бүрдсэн байна.

- Албан хаагчийг сэтгэл зүйн сөрөг үйлчлэлээс ангижруулах сэтгэл засал, алжаал тайлах үйлчилгээ тогтмолжсон байна.

- Албан хаагчийн гэр бүлийн гишүүдийн дунд халуун дулаан уур амьсгал бүрдсэн байна.

- Албан хаагч болон гэр бүлийн гишүүдийн дунд зохион байгуулагдах олон нийтийн арга хэмжээний үр нөлөө дээшилсэн байна.

#### **5 дугаар зорилтын хүрээнд:**

- Албан хаагч, ахмад настны дунд эрүүл мэндийн талаарх төрөлжүүлсэн судалгааны мэдээллийн сан бүрдсэн байна.

- Албан хаагч, ахмад настны эрүүл мэндийн боловсрол дээшилж, урьдчилан сэргийлэх болон нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээнд хамрагдсан байна.

- Албан хаагч, ахмад настан эмчилгээ, сувилгаанд хамрагдах нөхцөл бүрдсэн байна.

- Хамт олноороо хорт зуршлаас татгалзан, амьдралын эрүүл, зөв дадал хэвшил төлөвшүүлсэн байна.

#### **6 дугаар зорилтын хүрээнд:**

- Ахмад настны тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна.

- Байгууллагын захиргаа, "Ахмадын хороо"-ны хамтын ажиллагаа тогтмолжин жигдэрсэн байна.

- Ахмад настны хөгжил, хамгаалал, нийгмийн амьдралын оролцоо, түвшин сайжирна



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 413 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**“ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧИЙН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨР”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ (2021-2024 ОН)**

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хариуцах нэгж
<b>ЗОРИЛТ 1.</b> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагч, ахмад настны нийгмийн хамгааллыг бэхжүүлэхэд чиглэгдсэн эрх зүйн баримт бичиг, үйл ажиллагааны төлөвлөлтийг төрийн бодлого, шийдвэрт нийцүүлэн боловсронгуй болгох:				
1.	1.1. Байгууллагын хэмжээнд албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах чиглэлээр мөрдөгдөж буй баримт бичгүүдийн хэрэгжилт, үр нөлөөнд дүн шинжилгээ хийх.	2021 оны 3 дугаар улирал	- Эрх зүйн болон бодлогын баримт бичгүүдийн судалгааг гаргах. - Хэрэгжилт, үр нөлөөнд дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцох. - Зөрчил дутагдал, давхардал хийдлийг тогтоож арилгах.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
2.	1.2. Судалгааны үр дүнг үндэслэн албан хаагчдын дунд хэлэлцүүлэг, санал асуулга явуулан, дүнг нэгтгэж, албан хаагчдын нийгмийн хамгааллын асуудлыг зохицуулж буй хууль, бусад эрх зүйн актууд болон бодлогын баримт бичгүүдэд нэмэлт өөрчлөлт оруулах санал, төслийг боловсруулан зохих түвшинд уламжлан шийдвэрлүүлэх.	2022 он	- Хэлэлцүүлэг зохион байгуулж, эрх зүйн болон бодлогын баримт бичгүүдэд тусгах саналын төслийг тодорхойлсон байх. -Хууль, бусад эрх зүйн актууд болон бодлогын баримт бичгүүдэд нийгмийн хамгааллын бэхжүүлэх талаарх санал тусгагдсан байх.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
3.	1.3. Албан хаагч, ахмад настны нийгмийн хамгааллыг бэхжүүлэхэд чиглэгдсэн хууль тогтоомж, эрх зүйн акт, бодлогын баримт бичгүүдийг чанд мөрдөн, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцох.	2021-2024 он	- Эрх зүйн баримт бичгүүдийг байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж, хяналт тавьж, үр дүнг тооцсон байх. - Үр дүнг үндэслэн гүйцэтгэлийг сайжруулах арга хэмжээг тодорхойлсон байх.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
4.	1.4. Байгууллагын жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд албан хаагч, ахмад настны нийгмийн хамгааллыг	2021-2024 он	- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийгмийн хамгааллыг хангах, үр дүнг тооцох арга хэмжээг тогтмол тусгасан байх.	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага

	бэхжүүлэх талаар арга хэмжээ болон хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх асуудлыг тусган дүгнэх.		- Хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр үр дүнг тооцсон эсэх.	
<b>ЗОРИЛТ 2.</b> Байгууллагын хэмжээнд албан хаагчийн ажлын байрны орчин нөхцөлийг хэвийн, тасралтгүй явуулах, эрүүл ахуй, аюулгүй байдлын стандарт, шаардлагад нийцүүлэх:				
5.	2.1. Байгууллага бүр албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлыг жил бүр төлөвлөн, санхүүжилтийн асуудлыг тухайн жилийн төсвийн төсөвт тусгах болон байгууллагын дотоод эх үүсвэрээр бүрдүүлэх.	2021-2024 он	- ШШГЕГ болон анги, байгууллагууд жил бүр албан хаагч, ахмад настны нийгмийн хамгааллыг бэхжүүлэх төлөвлөгөө батлан, зардлыг тооцон, төсөвт тусгуулсан байх. - ШШГЕГ болон анги, байгууллагууд дотоод орлогын эх үүсвэрээс нийгмийн хамгааллыг бэхжүүлэх арга хэмжээнд зарцуулсан зардлын тоон үзүүлэлт.	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
6.	2.2. Төв байгууллага болон салбар нэгжийн хэмжээнд албан хаагчдын ажлын өрөө тасалгаа, бусад ажлын орчинг төрийн албаны стандартын шаардлагад нийцүүлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх.	2021-2024 он	- Албан хаагчдын ажлын өрөө тасалгаа, бусад орчинг төрийн албаны стандартад нийцүүлэн бүрдүүлсэн эсэх. - Албан хаагчдын албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх нөхцөл бүрдсэн байх.	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
7.	2.3. Байгууллагын хэмжээнд албан тушаалын ажлын байрны орчин нөхцөлд эрүүл ахуй, аюулгүй байдлын талаар дүн шинжилгээ хийж хэвших.	2021-2022 он	- Ажлын байрны орчин нөхцөлийн талаар судалгаа болон дүн шинжилгээ хийх. - Судалгааны дүнг үндэслэн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх. - Ажлын байрнаас үүсэх эрсдлийг тооцон үнэлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
8.	2.4. Албан хаагчдаас жил бүр ажлын байрны сэтгэл ханамжийн судалгаа авч, дүгнэлт гарган, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон, хэрэгжилтийг хангах.	2021-2022 он	- Сэтгэл ханамжийн судалгааны асуулгын агуулгыг зөв, оновчтой тодорхойлсон байх. - Албан хаагчдаас авах судалгааг тогтмолжуулан, жил бүр дүн шинжилгээ хийж хэвших. - Үр дүнг үндэслэн цаашид сайжруулах ажил, арга хэмжээг тодорхойлж, хэрэгжилтийг хангах.	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
9.	2.5. Ажлын орчин нөхцөл, хангамжийг хүйсийн ялгаатай байдал, онцлог хэрэгцээнд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих ажлыг хэрэгжүүлэх.	2021-2024 он	- Байгууллагын хэмжээнд ажлын орчин нөхцөл, хангамжийг хүйсийн ялгаамжтай байдалд нийцэж байгаа талаар судалгаа хийх. - Судалгааны үр дүнг үндэслэн зарим анги, байгууллагын ажлын орчин нөхцөлийг өөрчлөх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

10.	2.6. Албаны үйл ажиллагааг дэвшилтэт техник, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг тогтмолжуулах.	2021-2024 он	- Албан хаагчдын албан хэрэгцээнд ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмжийг шинэчилсэн тоон үзүүлэлт. - Албан хаагчдын албан үргээ гүйцэтгэх ажлын үзүүлэлт дээшилсэн байх.	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
11.	2.7. Албан хаагчийн албан ажилд шаардлагатай эрүүл ахуй, халдвар хамгаалал, бичиг хэргийн хэрэгцээт зүйлсээр зохих түвшинд хангах.	2021-2024 он	- Шаардлагатай тооцоо судалгааг гаргах. - Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан байдал.	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
12.	2.8. Албан хаагчийн батлагдсан нормативын шаардлагад нийцүүлэн ажлын ачаалалд дүн шинжилгээ хийн, удирдлагын түвшинд шийдвэр гаргах талаар санал уламжлах.	2021-2022 он	- Албан хаагчийн ажлын ачаалалд дүн шинжилгээ хийж, шаардлагатай орон тооны хэрэгцээг тодорхойлох. - Судалгааны үр дүнг үндэслэн санал шийдвэрлүүлэхээр холбогдох газарт уламжлах.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
13.	2.9. Орон тоог үе шаттай нэмэгдүүлэх асуудлыг эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх.	2021-2024 он	- Байгууллагын хэмжээнд шаардлагатай орон тооны судалгаа гарган, холбогдох байгууллагад шийдвэрлүүлэхээр уламжлах. - Орон тоог үе шаттайгаар нэмэгдүүлсэн тоон үзүүлэлт.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
14.	2.10. Албан хаагчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор нэг бүрийн бие хамгаалах тусгай хэрэгслээр хангаж, албаны тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг тогтмол хангах.	2021-2024 он	- Нэг бүрийн бие хамгаалах тусгай хэрэгслийн хангалтын талаарх судалгаа хийх. - Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэн, хангалтыг тогтмолжуулах. - Албан хаагчийн аюулгүй байдал хангагдсан байх.	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
15.	2.11. Албан хаагчдын дүрэмт хувцас, хэрэглэлийг хууль тогтоомжид заасны дагуу бүрэн, хугацаанд нь олгох ажлыг хэвшүүлэх.	2021-2024 он	- Албан хаагчдын дүрэмт хувцасыг хууль, журмын хүрээнд өөрчлөх. - Хууль, журмын хэрэгжилт хангагдсан байдал.	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
<b>ЗОРИЛТ 3.</b> Албан хаагчдын албан тушаалын эрх, үргээ хэвийн хэрэгжүүлэхэд шаардагдах эрх зүйн болон нийгэм, эдийн засгийн баталгааг бүрэн хангасны үндсэн дээр тэдний тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх.				
16.	3.1. Төрийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон бусад хууль тогтоомж, журам, зааварт тусгагдсан нийгмийн баталгааг бүрэн хангуулахад чиглэсэн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх.	2021-2024 он	- Хууль тогтоомж, эрх зүйн актаар олгогдсон нийгмийн баталгаагаар хангагдах боломжийг бүрдүүлсэн эсэх.	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
17.	3.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд албан хаагчдын	2021 он	- Амьжиргааны түвшин тогтоох суурь судалгаа хийх.	



	амьжиргааны түвшинг тогтоох суурь судалгаа хийж, судалгааны үр дүнд суурилан нийгмийн хамгааллын талаар авах арга хэмжээг оновчтой зохион байгуулах.			- Судалгааны дүнг үндэслэн хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцсон байх.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
18.	3.3. Албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан тусгай шалгуур, шаардлага, ажил үүргийн онцлог, ажлын нөхцөлийг харгалзан удирдах болон гүйцэтгэх түвшний албан хаагчдын цалинг үе шаттай нэмэгдүүлэх асуудлыг эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх.	2021-2024 он		- Албан хаагчдын цалин нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах арга хэмжээ авсан байх. - Албан хаагчдын цалин нэмэгдсэн тоон үзүүлэлт.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
19.	3.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан тушаалын мэргэжлийн ур чадварын зэргийн нэмэгдэл олгох журам боловсруулан, эрх бүхий байгууллагад уламжлан батлуулах.	2021-2023 он		- Албан тушаалын мэргэжлийн ур чадварын зэргийн нэмэгдэл олгох журам батлагдсан байх. - Мэргэжлийн ур чадварын зэргийн нэмэгдэл олгосон тоон үзүүлэлт.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
20.	3.5. Нийслэл, аймгийн төвөөс бусад алслагдсан нутаг дэвсгэрт тасралтгүй 5 болон түүнээс дээш жил ажиллаж байгаа алба хаагчдад мөнгөн урамшил олгох эрх зүйн зохицуулалтыг бий болгох төсөл боловсруулан шийдвэрлүүлэх.	2021 он		- Урамшуулал олгох эрх зүйн зохицуулалтын төслийг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх. - Мөнгөн урамшил олгох эрх зүйн зохицуулалт бүрдсэн байх.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
21.	3.6. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгч нарт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан "Яллантай ажилласны нэмэгдэл"-ийг олгох талаарх арга хэмжээг бодлогын түвшинд уламжлан, шийдвэрлүүлэх.	2021-2023 он		- Хуулийн хэрэгжилтийг хангах талаар холбогдох байгууллагад санал уламжлан шийдвэрлүүлсэн байх. - Албан хаагчийн нийгмийн баталгаа дээшилсэн байх.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
22.	3.7. Албан хаагч, ахмад настны амьдралын зайлшгүй шаардлага, нөхцөлийг үндэслэн нэг удаагийн тэтгэмж, буцалтгүй тусламж олгох арга хэмжээг хууль, журмын хүрээнд оновчтой зохион байгуулах.	2021 он		- Амьжиргааны түвшинг тогтоох судалгааг төрөлжүүлэн гаргаж, зайлшгүй шаардлагатай тусламж, тэтгэмжийн төрлийг тодорхойлох. - Тусламж, тэтгэмж олгох ажлыг тогтмолжуулснаар амьжиргааны түвшин дээшилсэн байх.	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага

23.	3.8. Байгууллагын албан хаагчдын хүүхдийн сурч боловсрох, мэргэжил, мэргэшлээ дээшлүүлэх, өсөж хөгжих боломжийг нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх зорилгоор дотоодын болон гадаад улсын их, дээд сургуульд элсэн суралцах хүүхдийн сургалтын төлбөрийг байгууллага хариуцах ажлыг тогтмолжуулах.	2021-2024 он	- ШШГБ-д ажиллах сонирхолтой албан хаагчдын хүүхдийн судалгаа гаргах. - Хамтран ажилладаг гадаад, дотоодын их, дээд сургаальд өөрсдийн хүсэл сонирхлын дагуу суралцуулах гэрээ байгуулж, төлбөрийг төлөх, хөнгөлөлт үзүүлэх. - Хамтран ажиллах их, дээд сургуулийн тоог нэмэгдүүлэх.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
24.	3.9. Албан хаагчдыг хөнгөлөлттэй нөхцөлөөр болон зах зээлийн үнээс хямд үнэтэй орон сууцаар хангах хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, чанартай, ая тухтай орон сууц худалдан авах, орчин, ахуй нөхцөлөө дээшлүүлэхэд /хашаа байшин, гэр/ нь дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэх.	2021-2024 он	- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нийт албан хаагчдыг зах зээлийн үнээс хямд үнэтэй орон сууцаар хангах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулсан байх. - Гэр, хашаа байшин худалдан авахад байгууллагын зүгээс хөнгөлөлт болон бусад дэмжлэг үзүүлсэн байх.	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
25.	3.10. Орон нутагт шилжин томилогдон ажиллаж байгаа албан хаагчийн албаны орон сууцаар хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх.	2021-2024 он	- Орон нутагт шилжин томилогдсон албан хаагчийг орон сууцаар хангасан тоон үзүүлэлт. - Албан хаагч тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэх.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
26.	3.11. Гэрт болон галлагаатай байшинд амьдардаг албан хаагчдад түлээ, нүүрс худалдан авахад дэмжлэг үзүүлэх.	2021-2024 он	- Байгууллагын хэмжээнд гэрт болон галлагаатай байшинд амьдардаг албан хаагчдын судалгаа гаргах. - Жил бүр хөнгөлттэй үнээр түлээ, нүүрс худалдан авахад нь дэмжлэг үзүүлсэн зардлын тоон үзүүлэлт.	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
27.	3.12. Өрх толгойлсон, олон хүүхэдтэй болон гэр бүлийн гишүүдийн дотор хөгжлийн бэрхшээлтэй, хүнд өвчтэй иргэн байгаа, арчилгаа, асрамж шаардлагатай эцэг, эхээ асардаг албан хаагчдад тусламж, дэмжлэг үзүүлэх.	2021-2024 он	- Байгууллагын хэмжээнд өрх толгойлсон, олон хүүхэдтэй болон гэр бүлийн гишүүдийн дотор хөгжлийн бэрхшээлтэй, хүнд өвчтэй иргэн байгаа, арчилгаа, асрамж шаардлагатай эцэг, эхээ асардаг албан хаагчдын судалгаа гаргах. - Тусламж, дэмжлэг үзүүлсэн тоон үзүүлэлт.	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
28.	3.13. Залуу гэр бүл, шинээр гэр бүл болсон албан хаагчийн гэр бүлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор тулгамдаж буй асуудлын хэрэгцээ шаардлагыг тодорхойлон, шаардлагатай дэмжлэг, тусламж үзүүлэх ажлыг тогтмолжуулах.	2021-2024 он	- Тулгамдаж буй асуудлыг тодорхойлсон байх. - Хэрэгцээ шаардлагад үндэслэн бодитой дэмжлэг үзүүлэх арга хэмжээг тогтмолжуулах. - Залуу алба хаагчдын идэвхтэй үйл ажиллагааг дэмжих, урамшууллын аргаар ажил хөдөлмөрт хандах хандлагыг идэвхжүүлэх, чиглүүлэх, сэдэлжүүлэх удирдлагын арга барилыг	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага

29.	3.14. Хөгжлийн бэрхшээлтэй, асаргаа сувилгаа шаардлагатай хүүхэдтэй албан хаагчдыг хууль тогтоомжийн хүрээнд богиносгосон цагаар ажиллуулах асуудлыг бодлогын түвшинд шийдвэрлүүлэх.	2021-2024 он	<p>нэвтрүүлэх.</p> <p>- Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах замаар албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх.</p>	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
30.	3.15. Хот суурин газраас алслагдсан байрлалд байгаа хорих анги, байгууллагын дэргэд хүүхдийн цэцэрлэг байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх.	2021-2024 он	<p>- Байгууллагын хэмжээнд хүүхдийн цэцэрлэг шаардлагатай байгаа анги, байгууллагын судалгааг гаргах.</p> <p>- Хүүхдийн цэцэрлэг байгуулах санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх.</p> <p>- Зарим анги, байгууллагад хүүхдийг цэцэрлэг байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлж, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байх.</p>	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
31.	3.16. Хүүхдийн хөгжил, хамгаалал, мэдлэг, боловсрол, хүмүүжил төлөвшлийг сайжруулах чиглэлээр албан хаагчид, тэдний гэр бүлийн гишүүд, хамт олны санаачилгаар олон нийтийн байгууллага, зөвлөлтэй хамтран хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг оновчтой, үр дүнтэй зохион байгуулах.	2021-2024 он	<p>- Гэр бүлийн хамгааллыг бэхжүүлэх олон талт арга хэмжээ зохион байгуулж, үр дүнг тооцсон байх.</p> <p>- Албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллах урам зориг нэмэгдсэн байдал.</p>	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
32.	3.17. Хот суурин газраас алслагдсан байрлалд томилогдсон албан хаагчийн гэр бүлийн гишүүнийг ажлын байраар хангах талаар дэмжлэг үзүүлэх ажлыг үргэлжлүүлэн холбогдох төр, захиргааны байгууллагатай хамтран ажиллах.	2021-2024 он	<p>- Тухайн орон нутгийн хөдөлмөрийн биржид бүртгэлтэй ажлын байрны судалгааг гаргах.</p> <p>- Гэр бүлийн гишүүдийг ажлын байраар хангах талаар хамтран ажиллах байгууллагын тоог нэмэгдүүлэх.</p> <p>- Ажлын байраар хангагдсан гэр бүлийн гишүүдийн тоон үзүүлэлт.</p>	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
33.	3.18. Албан хаагч, түүний гэр бүлийн гишүүдийг албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан хүчирхийлэл, заналхийлэл, доромжлол, гүтгэх бусад хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалалтад авах зохион байгуулалтын арга хэмжээ авах.	2021-2024 он	<p>- Хүчирхийлэл, заналхийлэл, доромжлол, гүтгэх болон бусад хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, батлах.</p> <p>- Хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцох.</p>	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага

<b>ЗОРИЛТ 4.</b> Албан хаагчдын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх арга хэмжээг тэдний авьяас чадварыг нээн илрүүлэх, хөгжүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх шаардлагатай нягт уялдуулан хэрэгжүүлэх:			
4.1. Төв байгууллага болон салбар нэгж бүр албан хаагч, ахмад настны дунд соён гэгээрүүлэх, эрүүл аж төрөх чиглэлээр сургалт, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах, бие даан өөрийгөө хөгжүүлэх сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах.	2021-2024 он	- Албан хаагч, ахмад настны дунд зохион байгуулах сургалтыг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах. - Анги, байгууллага бүр албан хаагчийн өөрийгөө бие даан хөгжүүлэх орчинг бүрдүүлэх. - Хамтран ажиллах байгууллагын тоог нэмэгдүүлэх.	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
4.2. Албан хаагчийг сэтгэл зүйн сөрөг үйлчлэлээс ангижруулах сэтгэл, заслын үйлчилгээ үзүүлэх, алжаал тайлах зориулалт бүхий өрөөг анги, байгууллагад бий болгон, үйл ажиллагааг тогтмолжуулах.	2021-2024 он	- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд алжаал тайлах зориулалт бүхий амралтын өрөөг нэмэгдүүлэх. - Албан хаагчдад сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдсэн байх.	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
4.3. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх, биеийн тамир, спортын үйл ажиллагаа явуулах зорилгоор бялдаржуулах танхим, спорт заалыг бий болгох.	2021-2024 он	- Байгууллагын хэмжээнд бялдаржуулах танхим, спорт заалыг нэмэгдүүлэх. - Спортоор хичээллүүлэх боломжийг хангаснаар албан хаагчид бие бялдар зөв тэгш болсон байх.	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
4.4. Байгууллагын хэмжээнд спортын дугуйлан ажиллуулах, албан хаагч болон тэдний гэр бүлийн гишүүдийн дунд төрөл бүрийн уралдаан, тэмцээн тогтмол зохион байгуулах.	2021-2024 он	- Албан хаагч болон гэр бүлийн гишүүдэд зориулсан спортын дугуйлангийн төрлийг нэмэгдүүлэх. - Дугуйланд хамрагдсан албан хаагч, түүний гэр бүлийн гишүүдийн тоон үзүүлэлт нэмэгдэх. - Спортын уралдаан тэмцээний төрлийг нэмэгдүүлэн, зохион байгуулах ажлыг тогтмолжуулсан байх.	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
4.5. Албан хаагч болон гэр бүлийн гишүүдийн дунд байгууллагын зүгээс мөн төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах.	2021-2024 он	- Хамтран ажиллах байгууллагын тоог нэмэгдүүлэх. - Олон нийтийн арга хэмжээг тогтмолжуулан, албан хаагч, гэр бүлийн гишүүдийг хамруулсан байдал.	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
<b>ЗОРИЛТ 5.</b> Албан хаагч, ахмад настуудын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах бодлогын үйл ажиллагааг тогтмолжуулан, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх:			
5.1. Албан хаагч, ахмад настны дунд мэргэжлээс шалтгаалах болон бусад	2021 он	- Мэргэжлээс шалтгаалах болон бусад өвчлөлийн талаар төрөлжүүлсэн судалгаа хийж,	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага

	<p>өвчлөлийн талаар төрөлжүүлсэн судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг тогтмолжуулах.</p>		<p>мэдээллийн сан бүрдүүлэх.  - Судалгааны дүнг үндэслэн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллаж, үр дүнг тооцох.  - Мэдээллийн сангийн баяжилтийг жил бүр тогтмол шинэчлэх.  - Албан хаагчдын өвчлөлийг бууруулсан тоон үзүүлэлт.</p>	<p>ШШГЕГ болон харьяа анги, байгууллага</p>
40.	<p>5.2. Албан хаагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл аж төрөх, эрүүл мэндээ хамгаалах, анхан шатны тусламж үзүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах.</p>	2021-2024 он	<p>- Сургалт зохион байгуулах чиглэлийг тодорхойлж, төлөвлөгөө батлан, хэрэгжилтийг хангах.  - Сургалтын тоон болон чанарын үзүүлэлтийг тооцох.</p>	<p>ШШГЕГ болон харьяа анги, байгууллага</p>
41.	<p>5.3. Албан хаагч, ахмад настанг жил бүр урьдчилан сэргийлэх болон нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээнд хамруулан шаардлагатай эмчилгээ, сувилгаа хийлгэх боломжоор хангах.</p>	2021-2024 он	<p>- Албан хаагч, ахмад настанг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахад шаардагдах зардлыг байгууллагын төсөвт тусгах.  - Байгууллагын хэмжээнд жил бүр албан хаагч, ахмад настанг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг тогтмолжуулах.  - Нарийн мэргэжлийн үзлэг шинжилгээнд хамрагдах шаардлагатай албан хаагч, ахмад настны судалгааг гарган, эмчилгээ, сувилгаанд хамруулах.  - Албан хаагч, ахмад настанг үзлэг шинжилгээнд хамруулсан тоон үзүүлэлтийн өсөлт нэмэгдэх.</p>	<p>ШШГЕГ болон харьяа анги, байгууллага</p>
42.	<p>5.4. Албан хаагчийн ур чадвар, зан төлөвшил нь тухайн албан тушаалыг гүйцэтгэхэд шаардагдах шаардлагуудтай тохирох эсэхийг нягтлах зорилгоор сэтгэл зүйн тестийн судалгаа хийж, үр дүнг тооцох, энэ чиглэлээр мэргэшсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэх.</p>	2021-2022 он	<p>- Албан хаагчийн дунд сэтгэл зүйн тестийн судалгаа хийж, мэдээллийн сан бүрдүүлэх.  - Албан хаагч тухайн албан тушаалыг гүйцэтгэхэд тавигдах шаардлагыг хангаж байгаа байдалд ашиглаж хэвших.</p>	<p>ШШГЕГ болон харьяа анги, байгууллага</p>
43.	<p>5.5. Албан хаагчийн сэтгэл зүйг тогтворжуулах, стрессийг бууруулах сургалтыг тогтмол зохион байгуулж, үр дүнг тооцох.</p>	2021-2024 он	<p>- Мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах.  - Сургалтын чанар, үр нөлөөг тогтмол тооцох.</p>	<p>ШШГЕГ болон харьяа анги, байгууллага</p>

44.	5.6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд албан хаагч болон ахмад настны эрүүл мэндийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх “Төр хур” нөхөн сэргээх амралт, сувиллын үйл ажллагааг өргөтгөн тогтмолжуулах.	2021-2024 он	<ul style="list-style-type: none"> <li>- “Төр хур” нөхөн сэргээх амралт, сувиллын газрын сувиллын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг авах.</li> <li>- Үйл ажиллагааг жигдрүүлэн тогтмолжуулсан байх.</li> </ul>	ШШГЕГ, “Төр хур” нөхөн сэргээх амралт, сувиллын газар
45.	5.7. Амралт, сувиллын газруудтай хамтран ажиллах гэрээ байгуулан, албан хаагч, ахмад настанг үнэ төлбөргүй болон хөнгөлттэй үнээр амруулахад дэмжлэг үзүүлэх ажлыг эрчимжүүлэх.	2021-2024 он	<ul style="list-style-type: none"> <li>- Хамтран ажиллах амралт, сувиллын газруудыг тоог нэмэгдүүлэх.</li> <li>- Албан хаагч, ахмад настныг амралтанд амрах, сувилалд сувиллуулахад хөнгөлөлт, дэмжлэг үзүүлсэн байх.</li> <li>- Амралт, сувиллын газруудад үйлчлүүлсэн нлбан хаагч, ахмад настны тоон үзүүлэлт, сэтгэл ханамжийн баталгаа нэмэгдсэн байх.</li> <li>- Хамтран ажиллах эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагын тоог нэмэгдүүлэх.</li> <li>- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний төрөл нэмэгдэж, чанар хүртээмж сайжирсан байх.</li> </ul>	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
46.	5.8. Албан хаагч, ахмад настанд эмнэлгийн тусламж, үйлчилгээг тасралтгүй, чанартай үзүүлэх чиглэлээр эрүүл мэндийн төрийн болон төрийн бус байгууллага, алба, нэгжтэй хамтын ажиллагааг өргөжүүлэн зохион байгуулах	2021-2024 он	<ul style="list-style-type: none"> <li>- Хамтран ажиллах эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагын тоог нэмэгдүүлэх.</li> <li>- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний төрөл нэмэгдэж, чанар хүртээмж сайжирсан байх.</li> </ul>	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
47.	5.9. Албан хаагч, ахмад настны гадаад, дотоодын эмнэлэгт эмчлүүлэх, амралт, рашаан сувилалд сувилуулахад дэмжлэг үзүүлж, хүнд өвчтэй албан хаагчийн эмчилгээний зардлыг бүрдүүлэхэд аян зохион байгуулах ажлыг тогтмолжуулах.	2021-2024 он	<ul style="list-style-type: none"> <li>- Эмчилгээний зардалд шаардагдах төсвийг жил бүрийн төсөвт тусгуулах.</li> <li>- Эмчилгээний зардалд тусламж, дэмжлэг үзүүлсэн байх.</li> <li>- Хүнд өвчтэй албан хаагчийн эмчилгээний зардлыг бүрдүүлэх аян өрнүүлж тусламж үзүүлэх ажлыг тогтмолжуулах.</li> </ul>	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
48.	5.10. Хөгжлийн бэрхшээлтэй албан хаагч, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг, тусламж үзүүлэх.	2021-2024 он	<ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн тусламж, дэмжлэг үзүүлэх шаардлагатай албан хаагч, ахмад настан, гэр бүлийн гишүүдийн хэрэгцээ шаардлагын судалгааг жил бүр шинэчлэн гаргах.</li> <li>- Хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчдад зориулсан ажлын орчин нөхцөлийг бүрдүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах.</li> <li>- Шаардлагатай тусламж, дэмжлэг үзүүлсэн байх.</li> </ul>	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
49.	5.11. Төв байгууллага болон салбар нэгж хорт зуршлаас татгалзах,	2021-2024 он	<ul style="list-style-type: none"> <li>- Хорт зуршлаас татгалзах аяныг тогтмол зохион байгуулж, албан хаагчдын идэвх, оролцоог</li> </ul>	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага

	амьдралын зөв дадал хэвшилтэй болох, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх, арга хэмжээг зохион байгуулах.		нэмэгдүүлэх. - Албан хаагчдын дунд амьдралын зөв дадал хэвшилтэй болох, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр олон нийтийн арга хэмжээг тогтмол зохион байгуулж хэвших.	
<b>ЗОРИЛТ 6.</b> Ахмад настанд үзүүлэх үйлчилгээг сайжруулан, зохих дэмжлэг, тусалцаа үзүүлэх:				
50.	6.1. Өндөр насны тэтгэвэр тогтоологх хугацаа дөхсөн болон өндөр насны тэтгэвэр тогтоологж байгаа ахмад настныг нийгэм, эдийн засаг, сэтгэл зүйн хувьд бэлтгэх арга хэмжээг тодорхой төлөвлөгөөний дагуу зохион байгуулах.	2021-2024 он	- Байгууллагын хэмжээнд ахмад настны судалгааг тогтмол шинэчилж, мэдээллийн сан бүрдүүлэх. - Жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ахмад настны нийгмийн хамгааллыг бэхжүүлэх арга хэмжээг тогтмол тусгаж, үр дүнг тооцож ажиллах.	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
51.	6.2. Ахмад настны аж байдлыг дээшлүүлэх зорилгоор амьдралын чанарын болон өвчлөлийн талаар судалгаа хийж, сууцны болон бусад дэмжлэг, тусалцаа, үйлчилгээ үзүүлэх.	2021-2024 он	- Ахмад настны өвчлөлийн талаар төрөлжүүлсэн судалгаа хийж, тогтмол шинэчлэх. - Ахмад настны амьдралын чанарын судалгаа хийж, шинэ төрлийн дэмжлэг, тусалцаа, үйлчилгээ нэвтрүүлэх. - Ахмад настанд үзүүлсэн тусламж, тэтгэмжийн чанарын үзүүлэлт.	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
52.	6.3. “Ахмадын сан” байгуулах үйл ажиллагааг нь бэхжүүлж, “Ахмадын хороо”-ны ажлыг тогтмолжуулан, дэмжиж урамшуулах арга хэмжээг хэрэгжүүлэх.	2021-2024 он	- Анги, байгууллага бүр “Ахмадын сан”-гийн санхүүгийн үйл ажиллагааг бэхжүүлэх. - Ахмадын хороо болон ахмадын зөвлөлийн даргыг мөнгөн болон бусад хэлбэрээр урамшуулах ажлыг тогтмолжуулах.	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
53.	6.4. Ахмад настанд асрамж, халамжийн үйлчилгээ, дэмжлэг тусалцаа үзүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус, буяны болон шашны байгууллагатай хамтран ажиллах.	2021-2024 он	- Хамтран ажиллах байгууллагын тоог нэмэгдүүлэх. - Тусламж, дэмжлэг үзүүлсэн тоон болон чанарын үзүүлэлт.	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
54.	6.5. Ахмад настанд зориулан чөлөөт цагийн танхим, өргөө бий болгох.	2021-2024 он	- Анги, байгууллага бүр ахмад настуудын үйл ажиллагаагаа явуулах чөлөөт цагийн танхим, өргөө байгуулахад дэмжлэг үзүүлэх. - Байгууллагын хэмжээнд чөлөөт цагийн танхим, өргөөг нэмэгдүүлсэн тоон үзүүлэлт.	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
55.	6.6. Тэмдэглэлт үйл явдал болон бусад баярыг тохиолдуулан шагнаж урамшуулах ажлыг тогтмолжуулах.	2021-2024 он	- Тэмдэглэлт үйл явдал болон бусад баярыг тохиолдуулан ахмад настанг шагнаж урамшуулахад дэмжлэг үзүүлэх. - Шагнал урамшуулалд хамрагдсан ахмад настны тоон үзүүлэлт.	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага

56.	6.7. Ахмад настны спортын баг, соёл, урлагийн хамтлаг, сонирхлын бүлэг, клубийг байгуулах, биеийн тамир, спорт, соёл, урлагийн арга хэмжээг зохион байгуулах.	2021-2024 он	<ul style="list-style-type: none"> <li>- Спорт, соёл, урлагийн хамтлаг, сонирхлын бүлэг, клубийг байгуулахад дэмжлэг үзүүлэх.</li> <li>- Урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулах.</li> <li>-Ахмад настны нас, бие бялдрын онцлог тохирсон сургалт, чийрэгжүүлэлт, дасгал хөдөлгөөнд хамруулах.</li> </ul>	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
57.	6.8. Ахмад настны туршлагыг дэлгэрүүлэх, мэргэжлийн ур чадварыг нь залуучуудад өвлүүлэх, ахмадаасаа суралцах, ахмад үеэ хүндэтгэж, дэмжин тусалдаг уламжлалт ёс заншлыг хадгалахад байгууллага, хамт олон, гэр бүлийн хамтын үйл ажиллагааг чиглүүлэх.	2021-2024 он	<ul style="list-style-type: none"> <li>- Ахмад настны ажил хөдөлмөрийн амжилт, амьдралын замнал, амжилт бүтээл, түүхэн гавьяа зэргийг олон нийтэд сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулах.</li> <li>- Ахмад настны хөдөлмөрийн алдрыг тэмдэглэх болон бусад хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулж, урамшуулах.</li> <li>- Ахмад настныг олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах, гадаад, дотоодын үзэсгэлэнт газруудаар аялахад дэмжлэг үзүүлэх.</li> </ul>	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага
58.	6.9. Ахмад настнууд залуу хойч үедээ ажил, амьдралын туршлагаасаа хуваалцах, зөвлөгөө өгөх, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах зэргээр тэдний идэвх, санаачлагыг хөхүүлэн дэмжих.	2021-2024 он	<ul style="list-style-type: none"> <li>- ШШГЕГ болон анги, байгууллага бүр ахмад настнууд залуу хойч үеийг холбосон олон нийтийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах.</li> <li>- Ахмадын зөвлөлөөс олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.</li> </ul>	ШШГЕГ болон харьяа анги, байгууллага

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ  
ЕРӨНХИЙ ГАЗАР